



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/72

Хэрлэн сум

“Монгол цэргийн өдөр”-ийг
тэмдэглэх тухай


Монгол улсын Засаг дахиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчнийг орон нутаг, ард иргэдэд сурталчлах, цэрэг иргэний холбоог бэхжүүлэх зорилгоор “Монгол цэргийн өдөр”-ийг 2024 оны 03 дугаар сарын 15-аас 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Монгол цэргийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг зохион байгуулах комисст, арга хэмжээнд зохион байгуулалттай оролцохыг Чингис хотод үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 103 ЖИЛИЙН ОЙ, “МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Комиссын дарга:	Ж.Гантулга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, хурандаа
Нарийн бичгийн дарга :	Б.Лхагвасамуу	Цэргийн штабын ОНХБС-ын офицер, ахлах дэслэгч
Гишүүд :	М.Бат-Очир	Зэвсэгт хүчний 232-р ангийн захирагч, дэд хурандаа
	П.Мөнхбаатар	Хилийн 0287-р ангийн захирагч, хурандаа
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа
	Д.Хатанбаатар	Шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа
	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа
	Ц.Батсайхан	МЦНХ-ны Хэнтий аймгийн дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 103 ЖИЛИЙН ОЙ, “МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

3 дугаар сарын 14-ны Пүрэв гариг

17.00-Цэрэгжлийн спортын цогцолбор тэмцээний техникийн зөвлөгөөнийг
аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулах.

3 дугаар сарын 15-ны Баасан гариг

10.00-Аймгийн Засаг даргын нэрэмжит шилдэг офицер, ахлагч шалгаруулах
тэмцээний нээлтийн арга хэмжээ

/АЗДТГ, зохион байгуулах комисс /

11.30-Партизан Б.Пунцагийн хөшөөнд цэцэг өргөх

/Зохион байгуулах комисс/

13.00-Удирдах бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдах “Дартс” шидэлтийн
тэмцээн

/Онцгой байдлын газар /

13.00-Гар бөмбөгийн тэмцээн

/Цагдаагийн газар /

15.00-Гар дээр суниалтын тэмцээн

/Тагнуулын хэлтэс /

15.00-Шатрын тэмцээн

/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /

3 дугаар сарын 16-ны Бямба гариг

10:00-Сүхбаатарын одонт хурандаа Ш.Дорж агсаны нэрэмжит “Цэрэг эрс-
2024” Марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээн

/Зэвсэгт хүчний 232 дугаар анги/

14.00-Буудлагын тэмцээн

/Хилийн 0287 дугаар анги/

18.00-Дүн гаргаж, шагнал гардуулах

/Зохион байгуулах комисс/